



НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2010 оны 03 сарын 26 өдөр

Дугаар 108

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Нийгмийн даатгалын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 4 дэх заалт, Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэг, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.11 дэх заалт, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2010 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. “Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны харилцааг зохицуулах журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, “Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны мэдээлэх хуудас-/ТДНД-01/” маягыг хоёрдугаар хавсралтаар, “Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны дэлгэрэнгүй бүртгэл-/ТДНД-02/” маягыг гуравдугаар хавсралтаар, “Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны нэгдсэн тайлан-/ТДНД-03/” маягыг дөрөвдүгээр хавсралтаар, “Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны мэдээлэх хуудсыг шалгуулах хүсэлт гаргах өргөдөл-/ТДНД-04/” маягыг тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Энэхүү журмын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газар /Ц.Дашдондог/, Хяналт, үнэлгээний газар /Ё.Пүрэвцэрэн/, Санхүү бүртгэлийн газар /З.Цэдэнжав/, Мэдээлэл тооцоолол, сургалтын төв /Г.Хүрэлбаатар/-д тус тус үүрэг болгосугай.

Гурав. Энэ тушаал гарсантай холбогдуулан Улсын нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2001 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 53, 54, 2002 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 21 дүгээр тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.



ДАРГА

Ч.АЛТАНХУЯГ



209

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2010 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 108 тоот тушаалын нэгдүгээр хавсралт

## ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН НЭРИЙН ДАНСНЫ ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилт нь Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуульд заасны дагуу тэтгэврийн даатгалд даатгуулсан иргэнд тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн данс (цаашид “нэрийн данс” гэх) нээх, уг дансны эхний үлдэгдэл тооцох, даатгуулагч болон ажил олгогчоос нэрийн дансанд төлсөн шимтгэлийг бүртгэх, нэрийн дансны тухайн жилийн орлогод хүү тооцох, нэрийн дансны бүртгэл тооцоо хөтлөх, мэдээлэх хуудас бэлтгэх, хүргүүлэх, даатгуулагчдын өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

### Хоёр. Нэрийн данс нээх

2.1. Нийгмийн даатгалын байгууллага нь дараахь даатгуулагчид нэрийн данс нээнэ.

2.1.1. Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан Монгол улсын иргэн, тус улсад байнга оршин суугаа гадаадын иргэн болон харъяалалгүй хүн (цаашид “даатгуулагч” гэх);

2.1.2. Нэрийн дансаа нээлгэх үед тэтгэврийн даатгалд хамрагдаагүй боловч өмнө нь ажил эрхэлж, эсхүл тэтгэврийн даатгалд даатгуулж байсан 1960 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр ба түүнээс хойш төрсөн иргэн.

2.2. Нэрийн дансыг дараахь баримтыг үндэслэн нээнэ.

2.2.1. Заавал даатгуулагчийн хувьд тухайн даатгуулагчийн ажиллаж байгаа аж ахуйн нэгж, байгууллага (цаашид “ажил олгогч” гэх)-ын харъяалах нийгмийн даатгалын байгууллага тухайн ажилтныг ажилд авсан тушаал, хөдөлмөрийн болон нийгмийн даатгалын дэвтэр, иргэний үнэмлэхийг үндэслэнэ.

2.2.2. Сайн дурын даатгуулагчийн хувьд тухайн даатгуулагчийн оршин суугаа газрын харъяа нийгмийн даатгалын байгууллага нь түүний хөдөлмөрийн болон нийгмийн даатгалын дэвтэр, иргэний үнэмлэхийг үндэслэнэ.

2.3. Даатгуулагчийн иргэний бүртгэлийн регистрийн дугаар нь түүний нэрийн дансны дугаар байна.

24

22

Гурав. Нэрийн дансны эхний (гарааны)  
үлдэгдэл тооцох

3.1. Нийгмийн даатгалын байгууллага нь заавал болон сайн дурын даатгалд хамрагдсан даатгуулагч тус бүрээр нэрийн дансны эхний үлдэгдлийг тооцно.

3.2. Нэрийн дансны эхний үлдэгдлийг Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлд заасны дагуу даатгуулагчийн нэрийн данс нээлгэх хүртэлх ажилласан, шимтгэл төлсөн хугацаа, индексжүүлсэн (итгэлцүүрээр тооцсон) цалин хөлсний хэмжээ зэрэг үзүүлэлтүүдийг үндэслэн тооцно.

3.3. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолд заасан хөдөлмөрийн хөлсний дундаж индекс (итгэлцүүр), 1995-1999 онд ажил олгогч болон даатгуулагчаас тэтгэврийн даатгалын санд төлөх шимтгэлийн хувь хэмжээг үндэслэн даатгуулагчийн нэрийн дансны эхний үлдэгдлийг тооцно.

3.4. Даатгуулагчийн нэрийн данс нээлгэх хүртэл (2000 он хүртэл) ажилласан нийт хугацааг дор дурдсан хугацаануудыг нэмэх замаар тодорхойлно:

3.4.1. Нийгмийн даатгалын тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хуулийн дагуу даатгуулагчийн 1995 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө ажилласан хугацааг хөдөлмөрийн дэвтэр (тушаалын хуулбар, архивын лавлагаа, шүүхийн шийдвэр, цэргийн батлах зэрэг)-ийг үндэслэн сараар тооцно;

3.4.2. Даатгуулагчийн 1995 оны 01 дүгээр сарын 01-нээс 1999 оны 12 дугаар сарын 31-нийг дуусталх шимтгэл төлсөн хугацааг нийгмийн даатгалын дэвтэр, мэдээллийн сан, шимтгэл төлөлтийн тооцооны хуудас (НД№8) зэргийг үндэслэн сараар тооцно;

3.5. Даатгуулагчийн нэрийн дансны эхний (гарааны) үлдэгдэл буюу 1995-1999 оны индекс (итгэлцүүр)-ээр тооцсон цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг дараахь байдлаар тодорхойлно. Үүнд:

3.5.1. Даатгуулагчийн 1995-1999 онд сар бүр шимтгэл төлж ажилласан 5 жилийн индексжүүлсэн (итгэлцүүрээр тооцсон) цалин хөлсний нийлбэрийг мөн хугацаанд шимтгэл төлсөн нийт сарын тоонд хуваана.

3.5.2. 1995 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө ажиллаж байсан боловч 1995 оноос хойш нэрийн данс нээлгэх хүртэлх хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлж ажиллаагүй даатгуулагчийн сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын хэмжээг Засгийн газраас тогтоон тухайн үед мөрдүүлж буй цалин хөлсний доод хэмжээ(12 000 төгрөгөөр )-гээр тооцно.

3.5.3. Даатгуулагч нь нэрийн данс нээлгэх хүртэл хугацаанд сар бүр тасралтгүй шимтгэл төлж ажиллаагүй нөхцөлд түүний төлсөн нийт шимтгэлээс нь тооцож гаргасан цалин хөлсний нийлбэрийг шимтгэл төлсөн нийт сарын тоонд хуваана.

3.5.4. Даатгуулагчийн нэрийн дансны эхний үлдэгдлийг тооцох сарын цалин хөлсний дээд хэмжээ нь Засгийн газраас тухайн үед тогтоосон даатгуулагчийн шимтгэл төлөх сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээ 425'000 (дөрвөн зуун хорин таван мянган) төгрөгнөөс хэтрэхгүй байна.

3.6. Нэрийн дансны эхний (гарааны) үлдэгдлийг дараахь байдлаар тооцно.

3.6.1. Энэ журмын 3.5-д заасны дагуу тооцсон даатгуулагчийн 1995-1999 оны цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг мөн журмын 3.3-д заасан шимтгэлийн хувь хэмжээгээр үржүүлж, тухайн онууд (1995-1999)-д төлсөн нийт шимтгэлийн хэмжээг тодорхойлно.

3.6.2. Энэ журмын 3.6.1- д заасан нийт шимтгэлийн хэмжээг уг хугацааны шимтгэл төлсөн нийт сарын тоонд хувааж нэг сард төлбөл зохих шимтгэлийн хэмжээг тооцно.

3.6.3. Нэг сард төлбөл зохих шимтгэлийн хэмжээг энэ журмын 3.4-д заасан хугацаагаар буюу сарын тоогоор үржүүлж, тухайн даатгуулагчийн нэрийн данс нээлгэх хүртэлх хугацаа (2000 он)-нд төлсөн нийт шимтгэлийн дүнг тооцно.

3.6.4. Тухайн даатгуулагчийн нэрийн данс нээлгэх хүртэлх хугацаа (2000 он)-нд төлсөн нийт шимтгэлийн дүнгээс 4.0 хувийг хасч нэрийн дансны эхний (гарааны) үлдэгдлийг тодорхойлно.

Дөрөв. Нэрийн дансны орлого бүртгэх

4.1. Даатгуулагчийн тухайн сард авсан цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос Нийгмийн даатгалын тухай хуульд заасан хувь хэмжээгээр суутган тэтгэврийн даатгалын санд ажил олгогч болон даатгуулагчаас төлсөн шимтгэлийг харъяалах нийгмийн даатгалын байгууллага төлбөрийн даалгавар, орлогын мэдүүлэг, даатгуулагчийн шимтгэлийн тооцооны хуудас (НД№8)-ыг тус тус үндэслэн даатгуулагч тус бүрийн нэрийн дансанд сар бүр орлогоор бүртгэнэ.

4.2. Хоёр ба түүнээс дээш аж ахуйн нэгж, байгууллагад хавсран ажилладаг даатгуулагчийн нэрийн дансны орлогыг тухайн даатгуулагчийн “Үндсэн ажлаас гадуур гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний орлогоос төлсөн шимтгэлийг бүртгэх хуудас” (НД№15)-ийг үндэслэн бүртгэнэ. Энэхүү дэвтэрт бичигдсэн цалин хөлс, төлсөн шимтгэлийн хэмжээг харъяалах нийгмийн даатгалын байгууллага хянаж баталгаажуулсан байна.

4.3. Тухайн жилд ажил олгогч, даатгуулагчаас тэтгэврийн даатгалын санд төлсөн шимтгэлийн нийлбэрээр уг даатгуулагчийн нэрийн дансны нийт шимтгэлийн орлогыг (НШО) тодорхойлно.

4.4. Тухайн жилийн нийт шимтгэлийн орлогоос энэ журмын 6.2.-д заасан тусгай сангийн зардал (ТСЗ)-ыг хасч бүртгэсэн шимтгэлийн орлого (БШО)-ыг тодорхойлно.

## Тав. Нэрийн дансны хүү тооцох

5.1. Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасны дагуу Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөс тогтоосон хүүгийн хэмжээг баримтлан Нийгмийн даатгалын төв байгууллага нэрийн дансны хүү тооцно.

5.2. Даатгуулагч бүрийн нэрийн дансны эхний үлдэгдэл ба тухайн жилийн бүртгэсэн шимтгэлийн орлогын нийлбэрийг энэ журмын 5.1-д заасан хүүгийн хэмжээгээр өсгөж жилд нэг удаа хүүгийн орлого (ХО) тооцно.

## Зургаа. Нэрийн дансны эцсийн үлдэгдэл тооцох

6.1. Даатгуулагчийн нэрийн дансны тухайн жилийн эцсийн үлдэгдлийг тооцохдоо мөн оны эхний үлдэгдэл, тухайн жилд нэрийн дансанд бүртгэсэн шимтгэлийн орлого, түүнчлэн оны эхний үлдэгдэл болон тухайн жилд нэрийн дансанд бүртгэсэн шимтгэлийн орлогод тооцсон хүүгийн орлогын нийлбэрээс энэ журмын 6.2-т заасан зориулалтаар зарцуулах тусгай санд төвлөрүүлсэн хөрөнгийг хассан дүнгээр тодорхойлогдоно.

6.2. Нэрийн дансны тухайн жилийн тэтгэврийн даатгалын сангийн нийт орлогоос 4.0 (дөрөв) хүртэл хувийг тусгай дансанд төвлөрүүлэн хууль тогтоомжид заасан болзол журмын дагуу дор дурдсан зориулалтаар зарцуулна:

- 6.2.1. Тахир дутуугийн тэтгэвэр олгох ;
- 6.2.2. Тэжээгчээ алдсаны тэтгэвэр олгох ;
- 6.2.3. Бусад үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх.

6.3. Даатгуулагчийн нэрийн дансны тухайн оны эцсийн үлдэгдэл нь дараа оны эхний үлдэгдэлтэй тэнцүү байна.

6.4. Давхар ажил эрхэлдэг даатгуулагчийн нэрийн дансанд бүртгэсэн тухайн жилийн шимтгэлийг тооцохдоо ажил олгогч тус бүрийн төлсөн шимтгэлийн нийлбэрээс энэ журмын 6.2-т заасан зардлыг хасч тооцно.

6.5. Шилжилт хөдөлгөөн хийлгэсэн даатгуулагчийн нэрийн дансанд урьд нь нийгмийн даатгалын байгууллага бүрт бүртгэгдсэн шимтгэлийн нийлбэрээр түүний тухайн жилийн нийт шимтгэлийн орлого тооцогдоно.

Долоо. Нэрийн дансны бүртгэл хөтлөлт,  
тайлан мэдээ хүргүүлэх

7.1. Нийгмийн даатгалын байгууллага нь нэрийн дансны анхан шатны дараахь маягтуудыг хөтөлнө:

- 7.1.1. Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны мэдээлэх хуудас (Маягт ТДНД-01)
- 7.1.2. Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны дэлгэрэнгүй бүртгэл (Маягт ТДНД-02)
- 7.1.3. Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны нэгдсэн тайлан (Маягт ТДНД-03)
- 7.1.4. Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны мэдээлэх хуудсыг шалгуулах хүсэлт гаргах өргөдөл (Маягт ТДНД-04)

7.2. Нийгмийн даатгалын байгууллага нь нэрийн дансны дэлгэрэнгүй бүртгэл (ТДНД-02)-ийг даатгуулагчийн шимтгэлийн тооцооны хуудас (НД№8)-ыг үндэслэн сар бүр бүртгэж, жилийн эцэст даатгуулагчийн нэрийн дансны үлдэгдлийг тодорхойлох бөгөөд уг бүртгэлийг “Нийгмийн даатгалын байгууллагын архивын ажлын заавар”-ын дагуу архивт шилжүүлнэ.

7.3. Нийгмийн даатгалын байгууллага нь нэрийн дансны жилийн нэгдсэн тайлан (ТДНД-03)-г дараа оны 1 дүгээр улиралд багтаан гаргана.

Найм. Нэрийн дансны мэдээлэх хуудас бэлтгэх,  
даатгуулагчдад хүргүүлэх

8.1. Мэдээлэл тооцоолол, сургалтын төв нь нийгмийн даатгалын байгууллагын мэдээллийн сангийн баазад бүртгэгдэж тооцоо хийгдсэн даатгуулагчдын цалин хөлс, шимтгэл төлөлтийн жилийн эцсийн мэдээлэл, тайланг үндэслэн нэрийн дансны тухайн жилийн эцсийн үлдэгдлийг даатгуулагч тус бүрээр гаргаж, мэдээлэх хуудсыг хэвлэмэл (цаасан) эсхүл цахим хэлбэрээр бэлтгэн, түүнийг нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагуудад хүргэх ажлыг дараа оны 1 дүгээр улиралд багтаан зохион байгуулна.

8.2. Нийгмийн даатгалын орон нутгийн байгууллага нь энэ журмын 8.1-д заасны дагуу ирүүлсэн нэрийн дансны мэдээллийг хүлээн авч, өөрийн мэдээллийн сангийн баазын холбогдох мэдээлэлтэй тулган шалгаж баталгаажуулна.

8.3. Нийгмийн даатгалын орон нутгийн байгууллага нь тухайн жилийн нэрийн дансны мэдээлэх хуудсыг даатгуулагчдад дараахь байдлаар хүргүүлнэ:

- 8.3.1. Тайлант хугацаанд шимтгэл төлсөн заавал даатгуулагчийн нэрийн дансны мэдээлэх хуудас (Маягт ТДНД-01) -ыг тухайн ажил олгогчид нь буюу даатгуулагчид нь дараа оны хоёрдугаар улиралд багтаан хүргүүлнэ.
- 8.3.2. Тайлант хугацаанд сайн дураар даатгуулж шимтгэл төлсөн даатгуулагч нь нэрийн дансны мэдээлэх хуудас (Маягт ТДНД-01)-ыг шимтгэл төлсөн нийгмийн даатгалын байгууллага (байцаагч)-аас өөрийн биеэр очиж авна.
- 8.3.3. Тэтгэврийн даатгалын санд заавал болон сайн дураар даатгуулж байсан боловч сүүлийн жилд шимтгэл төлж ажиллаагүй даатгуулагч өөрөө хүсвэл хамгийн сүүлд шимтгэл төлж байсан нийгмийн даатгалын байгууллага/ байцаагч/-аас тухайн жилийн нэрийн дансны мэдээлэх хуудас (Маягт ТДНД-01)-ыг хэвлүүлэн авч болно.

8.4. Даатгуулагч нь мэдээлэх хуудсыг хүлээн аваад өөрийн нэрийн дансанд бүртгэсэн цалин хөлс, үүнээс тооцсон шимтгэлийн тухай мэдээлэл үнэн зөв, мөн шимтгэл хугацаандаа төлөгдөж байгаа эсэхийг хянаж, хэрэв мэдээлэл буруу байвал харъяалах нийгмийн даатгалын байгууллагаар тухайн мэдээлэх хуудсанд бичигдсэн мэдээллийг залруулж авах эрхтэй.

8.5. Даатгуулагчийн мэдээлэх хуудсыг жилд нэг удаа хүргүүлнэ. Мэдээлэх хуудсыг даатгуулагч өөрийн хүсэлтээр дахин гаргуулж авах тохиолдолд мэдээлэх хуудас бэлтгэх зардлыг даатгуулагч өөрөө хариуцна. Энэ журмын 7.1.4-т заасны дагуу хүсэлт гаргаж, мэдээлэх хуудсаа залруулж авах тохиолдолд энэ заалт хамаарахгүй.

8.6. Нийгмийн даатгалын төв байгууллага нь даатгуулагчдын нэрийн дансны талаарх мэдээллийг өөрийн байгууллагын албан ёсны вебсайт хаягаар даатгуулагчид хүргэж болно.

**Ес. Даатгуулагчийн өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх**

9.1. Даатгуулагч нэрийн дансны мэдээллийн талаарх өргөдөл, гомдолоо харъяалах нийгмийн даатгалын байгууллагад бичиг (Маягт ТДНД-04)-ээр гаргана.

9.2. Нийгмийн даатгалын байгууллага (хэлтэс) нь хүлээж авсан даатгуулагчийн өргөдөл, гомдолд дурдсан асуулгыг холбогдох (өмнөх) бусад нийгмийн даатгалын байгууллага (хэлтэс)-аас авч, нэгтгэн түүний өргөдөл, гомдлыг бүрэн барагдуулах үүрэгтэй.

9.3. Нийгмийн даатгалын байгууллага нь даатгуулагчийн гаргасан өргөдөл, гомдлыг нь “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдол шийдвэрлэх тухай хууль”-д заасан хугацаанд шийдвэрлэнэ.

9.4. Нийгмийн даатгалын улсын байцаагч даатгуулагчийн нэрийн дансны мэдээлэх хуудасанд бүртгэгдсэн мэдээллийн үндэслэлийг ажил олгогчоос ирүүлсэн шимтгэл төлөлтийн тайлан, тооцооны хуудас, даатгалын гэрээнд тусгагдсан заалт, шимтгэл төлсөн орлогын баримт болон тэтгэврийн сангийн харилцах дансны гүйлгээтэй тулган шалгаж шийдвэрлэсний үндсэн дээр уг залруулсан зөв мэдээлэлд гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулан нэрийн данс хариуцсан байцаагчид өгнө.

9.5. Нэрийн данс хариуцсан байцаагч нь залруулсан мэдээллийг тухайн хэлтсийн даргын бичгээр өгсөн зөвшөөрлийн дагуу шимтгэлийн байцаагчид өгч уг мэдээллийг засварлуулах бөгөөд тухайн ажил олгогч, даатгуулагчийн шимтгэл төлөлтийн тооцоог дахин нягталж, үлдэгдлийг баталгаажуулах замаар түүний нэрийн дансны мэдээлэх хуудсыг залруулан дахин хэвлэж өгнө.

9.6. Нийгмийн даатгалын байгууллага нь даатгуулагчийн нэрийн дансны орлогын мэдээлэлтэй холбоотой зөрчлийг арилгаж, түүний өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн талаар холбогдох тэмдэглэл хөтөлж, уг тэмдэглэлийг тухайн даатгуулагчийн гаргасан өргөдлийн хамт архивт хадгална.

Арав. Журмын хэрэгжилтэд тавих хяналт,  
хүлээлгэх хариуцлага


10.1. Энэ журмын хэрэгжилтэд нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагын холбогдох чиг үүрэг бүхий нэгж, нийгмийн даатгалын улсын байцаагч хяналт тавина.

10.2. Энэхүү журмыг зөрчигчдөд хууль, тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

----- оОо -----



Маягт ТДНД-01



217

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2010 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 108 тоот тушаалын хоёрдугаар хавсралт



### ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН НЭРИЙН ДАНСНЫ МЭДЭЭЛЭХ ХУУДАС

Даатгуулагчийн

Эцэг/эхийн нэр: Эцэг /эхийн нэр

Нэр: Өөрийн нэр

Регистрийн дугаар : 0000000000


Ажил олгогчийн нэрс:

20\_\_ оны эхний үлдэгдэл:

(үүнээс гарааны үлдэгдэл: \_\_\_\_\_)

Сар	Цалин хөлс, түүнтэй адилтгах орлого	Нийт шимтгэлийн орлого (НШО)		Тусгай сангийн зардал (ТСЗ)	Бүртгэсэн шимтгэлийн орлого (БШО)
		Ажил олгогч	Даатгуулагч		
	I	II	III	IV	V
1					
2					
3					
4					
5					
6					
7					
8					
9					
10					
11					
12					
Дүн					
Хүүгийн орлого (ХО: _____ хувь)					

20\_\_ оны эцсийн үлдэгдэл :



\_\_\_\_\_-ЫН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС

цв 9

## САНАМЖ

Энэхүү тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны мэдээлэх хуудас нь /Маягт ТДНД-01/ Монгол Улсын Нийгмийн даатгалын тухай, Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай, Нийгмийн даатгалын хуулиудыг хэрэглэх журмын тухай болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу нийгмийн даатгалд хамрагдаж буй даатгуулагч иргэн таны нэрийн дансны орлогыг мэдээлэх зорилготой болно.

Хэрэв та нийгмийн даатгалд хамрагдсан заавал даатгуулагч бол ажил олгогчийн харьяалах нийгмийн даатгалын хэлтэст хандаж мэдээлэх хуудсаа /Маягт ТДНД-01/ авч болох бөгөөд сайн дурын даатгалд даатгуулагч бол оршин суугаа хаягийн бүртгэлээр харьяалах нийгмийн даатгалын хэлтэстээ хандана.

Даатгуулагч та 2000 оноос өмнө буюу нэрийн данс нээлгэх хүртэл хугацаанд хөдөлмөр эрхэлж, шимтгэл төлж цалин хөлс, түүнтэй адилтгах орлого олж байсан бол харьяалах нийгмийн даатгалын хэлтэстээ хандаж зохих журмын дагуу нэрийн дансны эхний (гарааны) үлдэгдлээ тооцуулна уу.


Нэрийн дансны тооцооны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг [www.ndaatgal.mn](http://www.ndaatgal.mn) хаягаар хандаж үзнэ үү.

Таны ирээдүйн нийгмийн хамгааллын баталгаа болох тэтгэврийн хэмжээ нь нэрийн дансанд бүртгэгдсэн дүнгээс хамаарах тул шимтгэл цаг хугацаандаа бүрэн, үнэн зөв төлөгдөж буй эсэхэд анхаарч, хуримтлалаа нэмэгдүүлж байхыг танд зөвлөж байна.

Энэхүү мэдээлэх хуудас нь аливаа арилжааны хэрэгсэл, санхүүгийн үүргийн гүйцэтгэлийг хангуулах баталгаа болохгүй бөгөөд зөвхөн мэдээллийн чанартай болно.

----- оОо -----

Маягт ТДНД-02



Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2010 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 108 тоот тушаалын гуравдугаар хавсралт

ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН  
НЭРИЙН ДАНСНЫ \_\_\_\_\_ ОНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ БҮРТГЭЛ

Хэлтэс (газар)-ийн нэр: \_\_\_\_\_

Ажил олгогчийн нэр: \_\_\_\_\_

Гэрчилгээний дугаар: \_\_\_\_\_

№	Овог нэр	Регистрийн дугаар	Цалин хөлс, түүнтэй адилтгах орлого	Нэрийн дансны эхний үлдэгдэл	Нийт шимтгэлийн орлого (НШО)	Тусгай сангийн зардал (ТСЗ)	Бүртгэсэн шимтгэлийн орлого (БШО)	Хүүгийн орлого (ХО)	Нэрийн дансны эцсийн үлдэгдэл
А	Б	В	1	2	3	4	5	6	7

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА \_\_\_\_\_ /


/

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ \_\_\_\_\_ /

/

2010

Маягт ТДНД-03



Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2010 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 108 тоот тушаалын дөрөвдүгээр хавсралт

ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН НЭРИЙН ДАНСНЫ  
\_\_\_\_\_ ОНЫ НЭГДСЭН ТАЙЛАН

Хэлтэс (газар)-ийн нэр \_\_\_\_\_

Он	Даатгуулагчийн тоо	Цалин хөлс, түүнтэй адилтгах орлого	Нэрийн дансны эхний үлдэгдэл	Нийт шимтгэлийн орлого (НШО)	Тусгай сангийн зардал (ТСЗ)	Бүртгэсэн шимтгэлийн орлого (БШО)	Хүүгийн орлого (ХО)	Нэрийн дансны эцсийн үлдэгдэл
А	Б	1	2	3	4	5	6	7
2000								
2001								
2002								
2003								
2004								
.....								

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА \_\_\_\_\_ /

/


ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ \_\_\_\_\_ /

/

----- оОо -----

2010

Маягт ТДНД-04



Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2010 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 108 тоот тушаалын тавдугаар хавсралт

ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН НЭРИЙН ДАНСНЫ МЭДЭЭЛЭХ ХУУДСЫГ ШАЛГУУЛАХ ХҮСЭЛТ ГАРГАХ ӨРГӨДӨЛ

Өргөдөл гаргасан даатгуулагчийн

Хэлтсийн нэр: \_\_\_\_\_

Овог: \_\_\_\_\_

Ажил олгогчийн нэр: \_\_\_\_\_

Нэр: \_\_\_\_\_

Регистрийн дугаар: \_\_\_\_\_

Нийгмийн даатгалын дэвтрийн дугаар: \_\_\_\_\_

Шалгалтад хамрагдах хугацаа: ..... оны ... сараас ..... оны ... сар хүртэл

Сар	Мэдээлэх хуудсаар хэвлэгдсэн			Даатгуулагчийн мэдүүлсэн			Нийгмийн даатгалын хэлтэс (газар)-ийн улсын байцаагч хянасан		
	Цалин хөлсний хэмжээ /төг/	Төлсөн шимтгэл		Цалин хөлсний хэмжээ /төг/	Төлсөн шимтгэл		Цалин хөлсний хэмжээ /төг/	Төлсөн шимтгэл	
		А/о	Дч		А/о	Дч		А/о	Дч
1									
2									
3									
4									
5									
6									
7									
8									
9									
10									
11									
12									
Дүн									

\_\_\_\_\_ овогтой \_\_\_\_\_ миний тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны мэдээлэх хуудсанд бүртгэгдсэн мэдээллийг нягталж, залруулж өгнө үү.

Гарын үсэг \_\_\_\_\_

Өргөдөл гаргасан: ..... он.. ... сар ..... өдөр

Нийгмийн даатгалын хэлтсийн дарга:

Нэр: \_\_\_\_\_

Гарын үсэг: \_\_\_\_\_

..... он .... сар .... өдөр

Мэдүүлгийг хянасан нийгмийн даатгалын улсын байцаагч:

Нэр: \_\_\_\_\_

Гарын үсэг: \_\_\_\_\_

..... он .... сар .... өдөр

Өргөдөл хүлээн авсан нийгмийн даатгалын байцаагч:

Нэр: \_\_\_\_\_

Гарын үсэг: \_\_\_\_\_

..... он .... сар .... өдөр

02

### ЗӨРЧЛИЙН ТАЛААРХ ТЭМДЭГЛЭЛ

Зөрчлийн утга: .....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....

Зөрчлийг арилгасан тухай тэмдэглэл: .....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....

Хянасан нийгмийн даатгалын хэлтсийн дарга:

Нэр: \_\_\_\_\_  
Гарын үсэг: \_\_\_\_\_  
..... он ..... сар ..... өдөр

Тэмдэглэл хөтөлсөн нийгмийн даатгалын улсын байцаагч:

Нэр: \_\_\_\_\_  
Гарын үсэг: \_\_\_\_\_  
..... он ..... сар ..... өдөр